



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/46/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Болдбаатар
Утас: 70512127 Цахим хаяг: boldbaatarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	1
1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.6.1 Төсвийн төлөвлөлт	12
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.6.3 Нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4 Аудитын илрүүлэлт	14
4.1 Төлбөрийн акт	14
4.2 Албан шаардлага	15
4.3 Зөвлөмж	15
1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518398, Факс: 70518398
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Бод. 02. 25. № 48
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН УУЛБАЯН
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Х.ЦОГТБААТАР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>123,198,677.00</u>	<u>144,266,676</u>
33	АВЛАГА	18,100,167.00	5,802,866.00
335	Бусад авлага	18,100,167.00	5,802,866.00
3351	Байгууллагаас авах авдага		5,302,866.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	18,100,167.00	500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	105,098,510.00	138,463,810.00
354	Хангамжийн материал	30,438,510.00	63,408,810.00
35410	Бичиг хэргийн материал	817,110.00	1,022,410.00
35420	Аж ахуйн материал	22,535,300.00	26,365,300.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,568,500.00	6,703,500.00
35470	Бусад хангамжийн материал	5,517,600.00	29,317,600.00
35600	Мал амьтад	74,660,000.00	75,055,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,529,706,816.76</u>	<u>1,659,341,127.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,529,706,816.76	1,659,341,127.73
392	Биет хөрөнгө	1,525,545,616.76	1,655,179,927.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,275,519,331.39	1,383,295,875.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	-214,152,610.58	-291,654,759.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	172,744,800.00	139,354,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-77,032,816.65	-63,216,950.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	115,661,310.00	162,189,330.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-81,620,207.72	-93,633,049.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,892,330.00	50,892,330.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,844,070.16	-29,132,490.24
39214	Бусад үндсэн хөрөнгө	475,791,044.00	599,581,616.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-171,413,493.52	-202,496,774.14
393	Биет бус хөрөнгө	4,161,200.00	4,161,200.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,161,200.00	4,161,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,652,905,493.76</u>	<u>1,803,607,803.73</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,600,167.00	5,302,866.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,600,167.00	5,302,866.00
413	Өглөг	21,600,167.00	5,302,866.00
4136	Бусад өглөг	21,600,167.00	5,302,866.00
41361	Байгууллагад төлөх өглөг	21,600,167.00	5,302,866.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,631,305,326.76</u>	<u>1,798,304,937.73</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,631,305,326.76	1,798,304,937.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	388,407,412.66	388,407,412.66
51101	Өмч: - төрийн	388,407,412.66	388,407,412.66
512	Хуримтлагдсан үр дүн	1,107,919,880.59	1,274,919,491.56
51210	Өмнөх үеийн үр дүн	1,107,919,880.59	1,107,919,880.59
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	166,999,610.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	134,978,033.51	134,978,033.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,652,905,493.76</u>	<u>1,803,607,803.73</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,027,521,297.00	882,763,283.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	269,820,308.00	295,600,136.00
120	Нийтлэг татварын бус орлого	269,820,308.00	295,600,136.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	269,820,308.00	295,600,136.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	269,820,308.00	295,600,136.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	757,700,989.00	587,163,147.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	214,012,089.00	89,566,347.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,908,500.00	5,895,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,800,167.00	27,066,377.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,085,922.00	40,575,670.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,217,500.00	16,029,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	543,688,900.00	497,596,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	543,688,900.00	497,596,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	871,448,437.99	715,763,672.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	871,448,437.99	715,763,672.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	811,724,689.67	658,505,729.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,131,314.95	249,710,283.99
210101	Үндсэн цалин	183,272,051.54	176,306,624.98
210102	Нэмэгдэл	33,424,053.41	53,895,109.81
210104	Урамшуулал	00.00	7,183,378.41
210105	Гэрээт ажлын хөлс	14,435,210.00	12,325,170.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,464,098.75	31,422,657.97
210201	Тэтгэврийн даатгал	19,461,363.77	21,816,245.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,372,095.60	2,401,623.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,931,916.47	1,921,298.77
210204	Ажилгүйдлийн даатгал	718,778.92	480,242.78
210205	Эрүүл мэндийн даатгал	4,979,943.99	4,803,247.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,149,999.98	32,792,813.00
210301	Гэрэл, цахилгаан	8,499,999.98	7,729,353.00
210302	Түлш, халаалт	10,000,000.00	9,839,526.00
210303	Цэвэр, бохир ус	650,000.00	15,223,934.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,377,048.00	17,798,916.00
210401	Бичиг хэрэг	2,712,110.00	2,776,096.00
210402	Тээвэр, шатахуун	13,216,610.00	13,220,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,448,328.00	1,802,190.00
2105	Нормативт зардал	65,000.00	148,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	148,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	825,503.00	2,115,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	465,853.00	207,000.00
210604	Урсгал засвар	359,650.00	1,908,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,168,100.00	5,696,450.00
210702	Дотоод албан томилолт	3,168,100.00	5,696,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,021,600.00	18,934,300.00

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	18,262,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	619,000.00	269,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	235,200.00	235,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,400.00	101,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	46,000.00	46,000.00
210807	Газрын төлбөр	20,000.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	508,522,024.99	299,886,509.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	355,396,266.00	150,624,684.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	788,000.00	801,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	152,337,758.99	148,460,825.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,723,748.32	57,257,942.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,448,268.00	20,984,307.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8,248,268.00	8,184,307.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,210,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,989,700.00	12,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,275,480.32	36,273,635.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,275,480.32	36,273,635.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>156,072,859.01</u>	<u>166,999,610.97</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>156,072,859.01</u>	<u>166,999,610.97</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	388,407,412.66	134,978,033.51	1,107,919,880.59	00.00	1,631,305,326.76
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	388,407,412.66	134,978,033.51	1,107,919,880.59	00.00	1,631,305,326.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	388,407,412.66	134,978,033.51	1,107,919,880.59	00.00	1,631,305,326.76
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	166,999,610.97	00.00	166,999,610.97
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	388,407,412.66	134,978,033.51	1,274,919,491.56	00.00	1,798,304,937.73

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>757,700,989.00</u>	<u>587,163,147.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	757,700,989.00	587,163,147.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	214,012,089.00	89,566,347.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,908,500.00	5,895,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,800,167.00	27,066,377.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,085,922.00	40,575,670.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,217,500.00	16,029,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	543,688,900.00	497,596,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	543,688,900.00	497,596,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>715,255,989.00</u>	<u>580,248,147.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	715,255,989.00	580,248,147.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	655,532,240.68	522,990,204.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,831,314.95	249,710,283.99
210101	Үндсэн цалин	183,272,051.54	176,306,624.98
210102	Нэмэгдэл	33,124,053.41	53,895,109.81
210104	Урамшуулал	00.00	7,183,378.41
210105	Гэрээт ажлын хөлс	14,435,210.00	12,325,170.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,464,098.75	31,422,657.97
210201	Тэтгэврийн даатгал	19,461,363.77	21,816,245.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,372,095.60	2,401,623.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,931,916.47	1,921,298.77
210204	Ажилгүйдлийн даатгал	718,778.92	480,242.78
210205	Эрүүл мэндийн даатгал	4,979,943.99	4,803,247.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,149,999.98	32,792,813.00
210301	Гэрэл, цахилгаан	8,499,999.98	7,729,353.00
210302	Түлш, халаалт	10,000,000.00	9,839,526.00
210303	Цэвэр, бохир ус	650,000.00	15,223,934.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,377,048.00	17,882,216.00
210401	Бичиг хэрэг	2,712,110.00	2,859,396.00
210402	Тээвэр, шатахуун	13,216,610.00	13,220,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,448,328.00	1,802,190.00
2105	Нормативт зардал	65,000.00	148,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	148,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,251,503.00	2,707,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	591,853.00	207,000.00
210604	Урсгал засвар	1,659,650.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,168,100.00	6,196,450.00
210702	Дотоод албан томилолт	3,168,100.00	6,196,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,266,600.00	19,104,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	18,432,400.00

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	269,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	235,200.00	235,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,400.00	101,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	46,000.00	46,000.00
210807	Газрын төлбөр	20,000.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	350,958,576.00	163,025,684.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	350,170,576.00	162,224,684.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	788,000.00	801,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,723,748.32	57,257,942.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,448,268.00	20,984,307.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8,248,268.00	8,184,307.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,210,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,989,700.00	12,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,275,480.32	36,273,635.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,275,480.32	36,273,635.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>42,445,000.00</u>	<u>6,915,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>42,445,000.00</u>	<u>6,915,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>42,445,000.00</u>	<u>6,915,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	42,445,000.00	6,915,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,445,000.00	6,915,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-42,445,000.00</u>	<u>-6,915,000.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	502,596,800.00	466,626,030.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	502,596,800.00	466,626,030.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	481,602,400.00	445,641,723.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,337,100.00	249,710,283.99
210101	Үндсэн цалин	182,456,500.00	176,306,624.98
210102	Нэмэгдэл	65,734,700.00	53,895,109.81
210104	Урамшуулал	7,185,700.00	7,183,378.41
210105	Гэрээт ажлын хөлс	18,960,200.00	12,325,170.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,035,400.00	31,422,657.97
210201	Тэтгэврийн даатгал	26,062,000.00	21,816,245.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,743,400.00	2,401,623.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,194,700.00	1,921,298.77
210204	Ажилгүйдлийн даатгал	548,600.00	480,242.78
210205	Эрүүл мэндийн даатгал	5,486,700.00	4,803,247.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,150,000.00	18,218,879.00
210301	Гэрэл, цахилгаан	8,500,000.00	7,729,353.00
210302	Түлш, халаалт	10,000,000.00	9,839,526.00
210303	Цэвэр, бохир ус	650,000.00	650,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,083,500.00	17,703,216.00
210401	Бичиг хэрэг	2,850,800.00	2,680,396.00
210402	Тээвэр, шатахуун	13,232,700.00	13,220,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,802,190.00
2105	Нормативт зардал	148,800.00	148,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	148,800.00	148,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,301,000.00	3,301,000.00

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	801,000.00	801,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,173,400.00	6,196,450.00
210702	Дотоод албан томилолт	8,173,400.00	6,196,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,572,200.00	10,572,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,900,300.00	9,900,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	269,300.00	269,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	235,200.00	235,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,400.00	101,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	46,000.00	46,000.00
210807	Газрын төлбөр	20,000.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110801000.00	108368237.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,000,000.00	107,567,237.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	801,000.00	801,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20994400.00	20984307.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,994,400.00	20,984,307.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8,193,400.00	8,184,307.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	801,000.00	12,800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	502,596,800.00	466,626,030.96
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	502,596,800.00	466,626,030.96
132001	Орон нутгийн төсвөөс	502,596,800.00	466,626,030.96
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25.00
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17
620003	Үйлчлэх ажилтан	07	07

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,263,481.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,263,481.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,263,481.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,573,934.00
210303	Цэвэр, бохир ус	14,573,934.00
2104	Хангамж, бараа материалын зардал	289,000.00
210401	Бичиг хэрэг	289,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,532,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,532,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60868447.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,868,447.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	84263481.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,263,481.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,895,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,222,777.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,575,670.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,569,934.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, шилэн данс, авлагатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Болдбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ нь “Засаг даргыг цаг үеэ олсон бүх талын зөвлөгөө, мэдээллээр хангах, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг сум орон нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааны үр ашигтай, тасралтгүй жигд хэвийн нөхцөлийг баталгаатай хангах замаар улс төрийн аливаа нөлөөлөлд авталгүй иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд оршино” гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлжээ.

Зорилт:

- ✓ Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах;
- ✓ Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах;
- ✓ Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- ✓ Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- ✓ Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- ✓ Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- ✓ Тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг хангаж аж ахуйн талаар үйлчлэх.

- ✓ Татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээллийг гаргаж өгөх;
- ✓ Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан албан татварыг хураах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 871.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэв. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 715,8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.7 сая төгрөгөөс 70 хувиар буюу 7.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос **145.4** сая төгрөг буюу 8.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал

үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	18.1	5.8	-12.3
Бараа материал	105.1	138.5	33.4
Үндсэн хөрөнгө	1,529.7	1,659.3	129.6
Нийт хөрөнгө	1,652.9	1,803.6	150.7
Өр төлбөр	21.6	5.3	-16.3
Засгийн газрын оруулсан капитал	388.4	388.4	-
Хуримтлагдсан үр дүн	1,107.9	1,274.9	167.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	134.9	134.9	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,652.8	1,798.2	150.7

Бараа материалын дансны үлдэгдэл 138.5 сая төгрөг болж 33.4 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй бараа материал хүлээн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,659.3 сая төгрөг болж 145.4 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан 271.2 сая, урсгал төсвөөс худалдан авалтаар 6.9 сая, нийт 278.1 төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 33.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 148.5 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,798.2 сая төгрөг болж, 167.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 144.7 сая төгрөгөөр буюу 14.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан 25.8 сая төгрөгөөр орлого нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн орлого 124.4 сая, орон нутгийн санхүүжилт 46.1 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 155.6 сая төгрөг буюу 17.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 429.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 429.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 72.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 502.6 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь сонгуулийн үр дүнгээр ажилгүй болсон ажилчдын тэтгэмжийг нэмэгдүүлж баталсан нь нөлөөлсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд 502.6 сая төгрөгийн төсөв баталснаас 502,6 сая орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 497.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаанд 466.6 сая төгрөгийг зарцуулж, 30.9 сая төгрөгийг буцааж төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 466.6 сая төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс дутуу санхүүжилт авсантай холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 5.9 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 27.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 40.6 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 16.0 сая төгрөг нийт 89.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 14.6 сая, хангамж бараа материалын зардалд 0.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 8.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 60.9 сая нийт 84.3 сая төгрөгийг зарцуулж 5.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ-ын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд мэдээлсэн байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 зарлагын гүйлгээний 43.9 сая, урсгал санхүүжилтийн 16 гүйлгээний 511.8 сая төгрөгийг мэдээлээгүй Аудитын код: СБА-2022/46/НА-СТА-ТШЗ

тул зөвлөмж хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

3.9.2.1 Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”

3.9.2.2 Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ нь тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4 Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 53.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 0.5 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 53.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

4.1 Төлбөрийн акт

4.1.1 Томилолтын зардлаас 0.5 сая төгрөгийн урьдчилгаа олгоод суутган тооцоогүй авлагаар илэрхийлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, болон иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.2 Албан шаардлага

4.2.1 Цэвэр бохир ус, албан томилолт, бичиг хэргийн зардлаас 3.7 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹, 6.4.2², 16 дугаар зүйлийн 16.5.5³, 41 дүгээр зүйлийн 41.2.3⁴ дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 03 сарын 14-ний өдрийн 55 тушаалын 6 хавсралт болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2 Түлш халаалт, цэвэр бохир ус, урсгал засвар, дотоод албан томилолт, аудит, баталгаажуулах, зэрэглэл тогтоох, бараа үйлчилгээний бусад зардлаас 43.3 сая төгрөгийн материал, ажил үйлчилгээ худалдан авч хоорондын тооцооны дансаар бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дугаар заалт болон ажил гүйлгээний анги, үйл явдал, бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.2.3 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг баримтлалгүй иргэдийн наадмын зардал, залуучуудын байгууллагын тэмцээний шагнал, ойн медаль, бичгийн цаас принтерийн хорны хэрэглээ зэрэгт нийт 6,383.0 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 78 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

¹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

² төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;

³ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

⁴ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

Аудитын код: СБА-2022/46/НА-СТА-ТШЗ

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой

2.1 **Илрүүлэлт:** Шилэн дансны нэгдсэн сайтад тайлант хугацаанд оруулах мэдээллээс мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна. Энэ нь төсвийн нээлттэй, ил тод, цаг хугацаандаа байх зарчим алдагдаж олон нийт мэдээллээр цаг хугацаандаа мэдээллээр хангагдахгүй байна.

2.2 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ЗДТГ	6	53.9	-	-	1	0.5	3	53.5	2	-